



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/621

Мөрөн сум

Галт зэвсгийн тооллого зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Галт зэвсгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Хууль зүйн сайдын 2015 оны А/220 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Галт зэвсгийн тооллого явуулах зорилгоор “Зэвсэг-2024” арга хэмжээг аймгийн хэмжээнд 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулсугай.

2. “Зэвсэг-2024” арга хэмжээг зохион байгуулах, удирдлага зохион байгуулалтаар хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Гансүх (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Р.Машбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

С.Батхуяг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, хурандаа)

Б.Баасансүрэн (Хилийн 0257 дугаар ангийн захирагч, хурандаа)

Б.Эрдэнэбаатар (Хөвсгөл аймаг дахь Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа)

Ч.Хуншагай (Аймгийн Татварын хэлтсийн дарга)

П.Мөнхжаргал (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Сумын Засаг дарга нар

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Б.Алтанцог (Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалан тасгийн дарга, цагдаагийн хошууч)

3. “Зэвсэг-2024” нэгдсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж тайлан мэдээг 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор нэгтгэн танилцуулахыг ажлын хэсэг (Ц.Гансүх)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Г.Гандэлгэр)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ТӨМӨРБААТАР

Захирамж2024

6712011980